



BULIGAR
BOVINE SKIN TANNERY
EST. 1934

БУЛИГААР
хувьцаат компани

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

2026

АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	3
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай ТУЗ-ийн шийдвэр	4
Хурлын зар	6
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг	7
Танилцуулах баримт бичгийн жагсаалт	7
2025 оны үйл ажиллагааны тайлан	8
2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлан	14
2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт	22
Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоол	24
Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга	27
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төслүүд	31
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудасны загвар, санал хураалтын заавар	35

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын түүчээлэгч нарын нэг болж Монгол түүхий эдийн чанар бүтцэд тулгуурласан технологийн шийдлүүдийг эрэлхийлэн ажиллаж буй манай компанийн үйл ажиллагаа жилээс жилд өргөжин тэлсээр байна.

Бидний хувьд 2025 оны үйл ажиллагааны үр дүн, амжилт ололт болон цаашид хэрэгжүүлэх зорилтууд болон хөгжүүлэх ажлуудаа тайлагнах хариуцлагатай цаг ирлээ.

2025 онд Булигаар ХК-ийн хувьд үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон чанарыг ахиулах, хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх чиглэлд өндөр ач холбогдолтой хөрөнгө оруулалтуудыг хийсэн жил байлаа.

Нийт борлуулалтад эзлэх экспортын хэмжээ өмнөх онд 11% байснаас 2025 онд 0% болж буурсан нь үндсэн түүхий эд болох ямааны арьсны тоо болон чанарын үзүүлэлтүүд буурсантай холбоотой. Сүүлийн жилүүдэд тогтмол ажиглагдаж байсан энэхүү экспортын зах зээлийн агшилттай дотоодын нэмүү өртгийн сүлжээнд илүү чиглэсэн эцсийн боловсруулалт хийсэн савхины үйлдвэрлэл ба борлуулалтад төвлөрөн ажиллаж чадсанаар 2025 онд компанийн нийт борлуулалтын орлого 8.9 тэрбум төгрөг хүрч өмнөх оноос 4.2 хувийн өсөлттэй, дотоод борлуулалт өмнөх оноос 22 хувийн өсөлттэй байна.

Монгол улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүх-ийн

санаачилсан үндэсний “Цагаан Алт” хөтөлбөр ноос ноолуур болон арьс ширний салбарт хэрэгжиж эхэлснээр бид хөнгөлөлттэй зээл санхүүжилт авч үүний үр дүнд эцсийн бүтээгдхүүний чанар болон гарцыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлд дараах технологийн шинэчлэлүүдийг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- БНХАУ-с Yancheng Shibao компаниас 20 тонн түүхий эд ачаалах хүчин чадал бүхий 2 ширхэг даацын барбан худалдан авч суурилуулсан.
- БНХАУ-н “Brenu Industry” компаниас хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмжийг өсгөх чиглэлд 282 метр дамжуургын шугам авч суурилуулсан.
- БНХАУ-н “СНМ” компаниас халимлах машины өөх тос шахах, хусах дамжлагын зоргодос дамжуурга, шохойн барбанд үс шүүх систем зэрэг тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангаж зардал хэмнэх тоног төхөөрөмжүүдийг авч суурилуулсан.
- Итали улсын “СМ” компаниас орчин үеийн технологийн шийдэл, давуу талуудыг өөртөө бүрэн агуулсан сунгах машиныг авч суурилуулсан.
- Компанийн үндсэн хөрөнгө болох барилга байгууламж болон гадна дулааны шугам, бусад дэд бүтцийн засвар үйлчилгээг хийж шаардлагатай шинэчлэлүүдийг хийсэн.

Бид бүтээгдхүүний чанар болон хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлд шат дараатай технологийн болон хөдөлмөр зохион байгуулалтын шинэчлэлүүдийг богино хугацаанд хийхээр төлөвлөж байгаа бол дунд хугацаандаа тогтвортой хөгжлийн болоод хүрээлэн буй орчны шаардлагуудыг бүрэн хангах зорилгоор “Эмээлт эко” аж үйлдвэрийн цогцолборлуу нүүн шилжихээр төлөвлөн ажиллаж байна. Ингэснээр бид цаашид арьс ширний салбараас гарч буй хатуу хог хаягдлыг дахин боловсруулах, улмаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдхүүн үйлдвэрлэх, арьс шир боловсруулах технологийн дэвшлийг эх орондоо нутагшуулж байгалийн нөөц ашиглалтыг багасгах, сэргээгдэх нөөцийн хэрэглээг нэмэгдүүлэхийг эрхэмлэгч хариуцлагатай компани байхыг төлөө ажиллах болно.

Эрхэм хувьцаа эзэмшигчид, бидний хөдөлмөрч хамт олон, үнэнч харилцагчид, түншүүд болон бүхий л баялаг бүтээгч хамтрагч, оролцогч талуудынхаа дэмжлэгт гүнээ талархал илэрхийлье.

Та бүхэнд эрүүл энхийг хүсэж, цаашдын ажил үйлсэд нь өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн:

Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг

БУЛИГААР ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ



“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 03/26

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дахь заалт, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, компанийн 2026 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 13:00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, “Булигаар” ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.2. Компанийн ТУЗ-ийн гншүүдийг сонгох;
 - 2.3. Компанийн ТУЗ-ийн цалин урамшуулал, зардлын төсөв батлах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2026 оны 03-р сарын 03, 03-р сарын 18-ны өдрүүдэд өдөр тутмын сонивоор тус тус дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг Хавсралт №2-оор баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2026 оны 4 дүгээр сарын 17-ны 13.00 цаг хүртэл байна.
6. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах

- хороонд Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1, Хавсралт №2 дахь мэдээлэл болон компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт тус тус хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичгийг 2026 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
 8. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Б.Баттүшигийг, мөн хурал зохион байгуулах комиссын даргаар Г.Цэпилжид, гишүүнээр Н.Тэмүүжинг сонгосугай.
 9. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилон байгуулсугай.
Тооллогын комиссын дарга: Д.Энхзул
Тооллогын комиссын гишүүд: Ю.Дүгэрмаа, О.Тэмүүжин
 10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал, баримт бичигтэй ажлын өдрийн 09:00-17:00 цагийн хооронд хувьцаа эзэмшигчид танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Баттүшиг-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД



ХУРЛЫН ЗАР

“БУЛИГААР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 13:00 цагт “Булигаар” ХК-ийн байранд болох тул хувьцаа эзэмшигчдийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
3. Компанийн ТУЗ-ийн цалин урамшуулал, зардлын төсөв батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2026 оны 3 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд компанийн өөрийн байранд хурал зохион байгуулах комиссын гишүүд нараас холбогдох мэдээллийг авч танилцах боломжтой.

Холбоо барих утас: 99626299, 88862344, 91541004

И-мэйл хаяг: info@buligaar.com

“Булигаар” ХК-ийн албан ёсны хаяг, байршил:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо,
Арьс ширний үйлдвэрийн хашаа, Өөрийн байр.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

БУЛИГААР ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1.	Хурлын ирцийг бүртгэх (Тооллогын комисс)	5 минут
2.	Хурлын ирцийг мэдээлэх (Тооллогын комисс)	5 минут
3.	Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах (Хурлын дарга)	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах	70 минут
5.	Хурлын завсарлага	10 минут
6.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах (Тооллогын комиссын дарга)	5 минут
7.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах (Хурлын дарга)	5 минут
8.	Хурлыг хаах (Хурлын дарга)	10 минут

ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлт
3. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
4. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн тогтоол
5. Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө
6. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан
7. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв
8. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

БУЛИГААР ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Булигаар ХК нь 2025 онд 13.0 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй ажилласан бол бодит гүйцэтгэлээр 8,991.4 сая /9,890.1 сая/ төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөө 76 хувийн биелэлтэй ажиллаж, өмнөх оноос 4.2 хувиар өсгөж чадсан. Татварын дараа 302.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оноос 317%-ийн өсөлттэй байна. Бодын арьсны дундаж талбайн хэмжээ 2024 онд 223дм.кв байсан бол 2025 онд 245.7дм.кв болж 9.9%-иар өссөн.

БУЛИГААР ХК 2025 ОН

/2024 оны гүйцэтгэлтэй харьцуулав/



4.2%

8.99 тэрбум төгрөг
Борлуулалтын орлого

317%

302.9 сая
төгрөг
Цэвэр ашиг

22%

8.99 тэрбум төгрөг
Дотоод борлуулалт



22%

245.7 дм.кв

Бодын арьсны дундаж
талбайн хэмжээ /Монгол/

6.3%

501.29 төгрөг



/Нэгж дм арьсны үнэ/

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний
дундаж үнэ

Нийт борлуулалтын орлого

Plot Area (тэрбум, төгрөг)






Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн /эцсийн боловсруулалт/



Хөрөнгө оруулалт



Үр ашгийн тооцоо



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛТ

Бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, шинэ технологи, арга барилыг байнга нэвтрүүлэн ашигладаг бөгөөд хуучин технологио эрчим хүч, зардал бага зарцуулдаг орчин үеийн тоног төхөөрөмжөөр шинэчлэх хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийсээр байна. Энэхүү ажлын хүрээнд:

БНХАУ-с Yancheng Shibao компаниас 20 тонн түүхий эд ачаалах хүчин чадал бүхий 2 ширхэг даацын барбан худалдан авч суурилуулсан.

БНХАУ-н “Brenu Industry” компаниас хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмжийг өсгөх чиглэлд 282 метр дамжуургын шугам авч суурилуулсан.

БНХАУ-н “СНМ” компаниас халимлах машины өөх тос шахах, хусах дамжлагын зоргодос дамжуурга, шохойн барбанд үс шүүх систем зэрэг тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангаж зардал хэмнэх тоног төхөөрөмжүүдийг авч суурилуулсан.



Итали улсын “СМ” компаниас орчин үеийн технологийн шийдэл, давуу талуудыг өөртөө бүрэн агуулсан сунгах машиныг авч суурилуулсан.

Компанийн үндсэн хөрөнгө болох барилга байгууламж болон гадна дулааны шугам, бусад дэд бүтцийн засвар үйлчилгээг хийж шаардлагатай шинэчлэлүүдийг хийсэн.



2025 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “МОНГОЛ-ТУРКИЙН БИЗНЕС ФОРУМД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОВ.



БНТУ БОЛОН ХБНГУ-ЫН АРС ШИРНИЙ МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ ХАМТРАН ТУРШИЛТ СУДАЛГААНЫ АЖЛЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

БНТУ-ын СІНАН КІМҮА болон ХБНГУ-ын GREIBO CHEMIE компаниудын арьс ширний мэргэжилтнүүдтэй хамтран Монголын арьс ширний үйлдвэрийн технологич нар шинэ технологи хөгжүүлэх, одоо үйлдвэрлэж буй нэр төрлөө дараагийн шатанд гаргах, шинэ нэр төрлийн химийн материалуудтай танилцах туршилт судалгааны ажлыг амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээ нь сүүлийн үеийн дэвшилтэт будаг тослогоо болон өнгө заслын химийн материал, технологитой танилцахаас гадна Монгол арьсны онцлогт тохирох оновчтой шийдлүүдийг хамтаа эрэлхийлсэн цогц туршилт, судалгааны ажил боллоо.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛУУД

БОННУ-ИЙН ТАЙЛАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ



- Компанийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2024 онд 5 жилээр батлуулав.
- Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 5 жилээр авав.

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ, ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ



- Монгол Улсад мөрдөгдөж буй Байгаль орчны хууль, тогтоомж, стандартын шаардлагуудын хэрэгжилтийг үнэлэх Байгаль орчны аудитаар 87 шалгуур үзүүлэлтийн хүрээнд 89% гүйцэтгэлтэйгээр багц хуулийн нийцлийн аудитаар дүгнүүлэв.
- Тогтвортой хөгжлийн хүрээнд MNS 4724-1:2015 Арьс шир. Вет блю. Техникийн шаардлага стандартын шалгуурыг бүрэн хангаж, баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээг гардан авсан билээ.

НОГООН БАЙГУУЛАМЖ

Компанийн ажилтнуудын оролцоотойгоор СХД-ийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Инчон Мөрөөдлийн төгөл цэцэрлэгт хүрээлэнд 100 ширхэг мод тарив.

УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

Уурын конденсац үүссэн хаягдал усыг тусгай зориулалтын танканд хүлээн авч тоног төхөөрөмж угаах, цехийн цэвэрлэгээ үйлчилгээ, арьс анхан шатны тордолгоонд хэрэглэж байна.

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Орчны хяналт шинжилгээний дагуу хөрс, ус, агаарын мониторинг хийгдэв.

- Хөрсний шинжилгээг MNS3310:1991, MNS5850:2019, MNS6824:2020, MNS ISO11466:2007 стандартуудын үзүүлэлтийн дагуу микробиологи, хүнд металлыг тодорхойлох шинжилгээний 2 төрлөөр стандартын дагуу үзүүлэлтүүдийг хянаж зөвшөөрөгдөх хэмжээнд хэвийн үзүүлэлтийг хангав.
- Агаарын шинжилгээг MNS4585:2016 стандартын дагуу үзүүлэлтүүдийг хянаж зөвшөөрөгдөх хэмжээнд хэвийн үзүүлэлтийг хангав.
- Ундны усны шинжилгээний үр дүнг MNS9000:2018 стандартад нийцүүлэн хийсэн бөгөөд унд эрүүл ахуйн усны стандартад нийцсэн цэвэр аюулгүй, нянгийн бохирдолгүй байсан.

БУЛИГААР ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН, АУДИТЫН ДҮГНЭЛТ



СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК

Монголын МНБИ болон ТМЗН-ийн гишүүн байгууллага

“БУЛИГААР” ХК

(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

Улаанбаатар
2026 он

Сэрэлт Дөл Аудит ХХК нь хараат бус аудит, баталгаажуулалт, татварын болон зөвлөх үйлчилгээ, бизнесийн үйлчилгээ ба аутсорсинг, программ хангамж



Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2026.02.12 № СТА/26-16
танай _____ -ны № _____ -т

“БУЛИГААР” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “БУЛИГААР” ХК-ний 2025 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЭЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
“Булигаар” ХК-ны хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага(үргэлжлэл)

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд, тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно.
- ✓ Санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компанид хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)
 “Булигаар” ХК-ны хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлын талаар ярилцсан.

Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Бид олон нийгэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасны дагуу “Булигаар” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК
 Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот
 Огноо: 2026 оны 1. сарын 12



ДАЛТАНЦЭЦЭГ
 Захирал, ММНБ

“БУЛИГААР” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тод	2024.12.31	2025.12.31	Аудитлагдсан 2025.12.31
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	14,182,297.87	40,124,674.34	40,124,674.34
Дансны авлага	6	660,227,750.18	1,028,920,138.45	1,028,920,138.45
Татвар НДШ-ийн авлага				
Бусад авлага	6	8,525,397,517.89	10,130,759,909.68	10,130,759,909.68
Бараа материал	7	4,999,651,253.55	4,974,283,712.72	4,974,283,712.72
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			172,474,580.46	172,474,580.46
Эргэлтийн хөрөнгийн дүн		14,199,458,819.49	16,346,563,015.65	16,346,563,015.65
Үндсэн хөрөнгө	8	17,342,740,670.94	18,070,260,299.12	18,070,260,299.12
Биет бус хөрөнгө	9	316,822,448.81	274,587,169.88	274,587,169.88
Хойшлогдсон татварын хөрөнгө		588,301,125.38	642,529,562.14	642,529,562.14
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		18,247,864,245.13	18,987,377,031.14	18,987,377,031.14
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		32,447,323,064.62	35,333,940,046.79	35,333,940,046.79
Дансны өглөг	10	1,676,898,034.72	2,296,320,483.06	2,296,320,483.06
Татварын өр	10	234,024,057.44	376,247,652.21	376,247,652.21
НДШ-ийн өглөг		187,518,949.33	167,448,027.86	167,448,027.86
Богино хугацаат зээл	10	747,921,236.45	597,783,439.48	597,783,439.48
Хүүний өглөг	10	47,807,587.42	124,672,931.28	124,672,931.28
Ногдол ашгийн өглөг				
Урьдчилж орсон орлого				
Бусад богино хугацаат өр төлбөр		5,168,884,441.15	4,771,591,029.42	4,771,591,029.42
Богино хугацаат өр төлбөрийн дүн		8,063,054,306.51	8,334,063,563.31	8,334,063,563.31
Урт хугацаат зээл		1,535,430,883.00	4,247,238,629.19	4,247,238,629.19
Бусад урт хугацаат өр төлбөр		11,873,573,618.87	11,873,573,618.87	11,873,573,618.87
Урт хугацаат өр төлбөрийн дүн		13,409,004,501.87	16,120,812,248.06	16,120,812,248.06
Нийт өр төлбөрийн дүн		21,472,058,808.38	24,454,875,811.37	24,454,875,811.37
Хувийн өмч/ хувьцаат/	11	40,021,200.00	40,021,200.00	40,021,200.00
Халаасны хувьцаа				
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		8,308,751,508.03	7,909,556,226.13	7,909,556,226.13
Эздийн өмчийн бусад хэсэг		266,001,000.00	266,001,000.00	266,001,000.00
Хуримтлагдсан ашиг		2,360,490,548.21	2,663,485,809.29	2,663,485,809.29
Эздийн өмчийн дүн		10,975,264,256.24	10,879,064,235.42	10,879,064,235.42
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		32,447,323,064.62	35,333,940,046.79	35,333,940,046.79

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

“БУЛИГААР” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тод	2024.12.31	2025.12.31	Аудитлагдсан 2025.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	12	<u>8,628,311,765.90</u>	<u>8,991,446,032.19</u>	<u>8,991,446,032.19</u>
Борлуулалтын өртөг	13	7,381,077,650.94	7,584,464,374.43	7,584,464,374.43
Нийт ашиг /алдагдал/		<u>1,247,234,114.96</u>	<u>1,406,981,657.76</u>	<u>1,406,981,657.76</u>
Түрээсийн орлого		3,720,000.00		
Хүүний орлого		53,950.03		
Ногдол ашгийн орлого				
Бусад орлого		1,730,000.01		
Борлуулалт, маркетингийн зардал	14	176,486,201.97		
Ерөнхий ба удирдлагын зардал	14	969,844,219.12	1,001,929,442.86	1,001,929,442.86
Санхүүгийн зардал				
Бусад зардал	15	392,340.44	7,993,800.00	7,993,800.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	16	-94,336.49	-53,476,377.26	-53,476,377.26
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)				
Бусад ашиг (алдагдал)				
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		<u>105,920,966.98</u>	<u>343,582,037.64</u>	<u>343,582,037.64</u>
Орлогын татварын зардал	17	10,409,811.12	40,586,776.56	40,586,776.56
Татварын дараах ашиг (алдагдал)		<u>95,511,155.86</u>	<u>302,995,261.08</u>	<u>302,995,261.08</u>
Орлогын нийт дүн		<u>95,511,155.86</u>	<u>302,995,261.08</u>	<u>302,995,261.08</u>
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)				

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



“БУЛИГААР” ХК
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн жилийн хувьд

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	40,021,200.00	9,866,281,421.12	266,001,000.00	1,490,460,570.82	11,662,764,191.94
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	40,021,200.00	9,866,281,421.12	266,001,000.00	1,490,460,570.82	11,662,764,191.94
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				95,511,155.86	95,511,155.86
Өмчид гарсан өөрчлөлт				774,518,821.53	774,518,821.53
Дахин үнэлгээний нэмэгдэлийн дүн		-1,557,529,913.09			-1,557,529,913.09
Зарласан ногдол ашиг					
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	40,021,200.00	8,308,751,508.03	266,001,000.00	2,360,490,548.21	10,975,264,256.24
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	40,021,200.00	8,308,751,508.03	266,001,000.00	2,360,490,548.21	10,975,264,256.24
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				302,995,261.08	302,995,261.08
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-399,195,281.90			-399,195,281.90
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	40,021,200.00	7,909,556,226.13	266,001,000.00	2,663,485,809.29	10,879,064,235.42

“СЭРЭЛТ ДӨЛ” АЖ
АУДИТ
БҮГДЭЛЭГ ТОО

“БУЛИГААР” ХК

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн хувьд

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2024.12.31	2025.12.31	Аудитлагдсан 2025.12.31
Мөнгөн орлогын дүн (+)	<u>12,297,336,820.62</u>	<u>10,116,135,610.48</u>	<u>10,116,135,610.48</u>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,933,019,518.15	10,116,135,610.48	10,116,135,610.48
Бусад мөнгөн орлого	3,364,317,302.47		
Мөнгөн зарлагын дүн (-)	<u>8,542,568,865.60</u>	<u>11,182,491,263.12</u>	<u>11,182,491,263.12</u>
Ажиллагчдад төлсөн	968,606,602.70	913,839,108.10	913,839,108.10
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	606,436,057.91	269,074,813.10	269,074,813.10
Бараа материал худалдан авахад төлсөн	4,053,680,137.76	7,555,735,293.71	7,555,735,293.71
Ашиглалтын зардалд төлсөн	1,106,978,782.40	1,082,012,392.50	1,082,012,392.50
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	428,639,345.68	391,663,514.97	391,663,514.97
Хүүний төлбөрт төлсөн	402,402,546.34	180,105,701.86	180,105,701.86
Татварын байгууллагад төлсөн	499,030,989.94	470,410,402.32	470,410,402.32
Даатгалын төлбөрт төлсөн	238,275.00	175,168.00	175,168.00
Бусад мөнгөн зарлага	476,556,127.87	319,474,868.56	319,474,868.56
ҮҮАжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	<u>3,754,767,955.02</u>	<u>-1,066,355,652.64</u>	<u>-1,066,355,652.64</u>
Мөнгөн орлогын дүн	<u>57,510.30</u>		
Хүлээн авсан хүүний орлого	57,510.30		
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого			
Мөнгөн зарлагын дүн	<u>334,293,260.15</u>	<u>1,518,225,317.31</u>	<u>1,518,225,317.31</u>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	334,293,260.00	1,518,225,317.31	1,518,225,317.31
ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	<u>-334,235,749.85</u>	<u>-1,518,225,317.31</u>	<u>-1,518,225,317.31</u>
Мөнгөн орлогын дүн (+)	<u>1,793,935,000.00</u>	<u>4,720,000,000.00</u>	<u>4,720,000,000.00</u>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,793,935,000.00	4,720,000,000.00	4,720,000,000.00
Мөнгөн зарлагын дүн	<u>5,219,330,998.48</u>	<u>2,106,927,380.01</u>	<u>2,106,927,380.01</u>
Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	5,205,483,914.71	2,089,840,865.01	2,089,840,865.01
Бусад мөнгөн зарлага	13,847,083.77	17,086,515.00	17,086,515.00
СҮАжиллагааны мөнгөн гүйлгээний дүн	<u>-3,425,395,998.48</u>	<u>2,613,072,619.99</u>	<u>2,613,072,619.99</u>
Валютын ханшийн зөрүү	<u>-3,868,196.44</u>	<u>-2,549,273.57</u>	<u>-2,549,273.57</u>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>-8,731,989.75</u>	<u>25,942,376.47</u>	<u>25,942,376.47</u>
Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>22,914,287.62</u>	<u>14,182,297.87</u>	<u>14,182,297.87</u>
Мөнгө, түүнтэй адитгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>14,182,297.87</u>	<u>40,124,674.34</u>	<u>40,124,674.34</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.



БУЛИГААР ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ



“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 01/20

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт гаргах, Хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дах заалтуудыг тус тус удирдлага болгон Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
- Хоёр. Энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралт дахь ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Баттүшиг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2026 оны 2-р сарын 13-ны өдрийн
01/26 тоот тогтоолын Хавсралт 1

БУЛИГААР ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, Булигаар ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-ийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТУЗ нь өнгөрсөн оны ээлжит хурал дээр тус компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилтыг хэлэлцэн баталж, хэрэгжилт дээр компанийн дүрэм, журамд заасны дагуу тогтмол хяналтыг тавин, компанийн Гүйцэтгэх удирдлагын багийг санал зөвлөмж, үүрэг даалгавраар ханган чиглүүлж ажилласан бөгөөд Гүйцэтгэх удирдлагын баг нь ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө зорилт, шийдвэр, санал зөвлөмж, үүрэг даалгаврыг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.

ТУЗ-ийн баталсан 2025 оны бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны зорилт нь компанийн борлуулалтын орлогыг өмнөх оноос өсгөх, ашигт ажиллагааг сайжруулан ашгийн түвшинг нэмэгдүүлэх, дотоод борлуулалтын сувгийг нэмэгдүүлэн харилцагчид илүү ойртож ажиллах, хүний нөөцийн тогтвортой бодлогыг баримтлан ажиллах, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зэрэгт тус тус чиглэсэн.

2025 онд санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн хувьд 13 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй ажилласан бол бодит гүйцэтгэлээр 8,991.4 сая /9,890.1 сая ₮ НӨАТ-тэй/ төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөө 76%-ийн биелэлтэй ажиллаж, борлуулалтын орлого өмнөх оноос 4.2%-иар өссөн байна.

2025 онд нийт 1,735 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 96.8%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 3.2%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалтад зарцуулсан байна.

Хүний нөөцийн тогтвортой бодлого барих, бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг сайжруулах зорилгоор бүтэц, орон тоог тогтвортой барьж, үйлдвэрлэлийн бүтээл, гүйцэтгэлд суурилсан цалин хөлс, урамшууллын бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажилласан. 2025 онд бодын арьсны хувьд нийт үйлдвэрлэл 19%-иар өсөж, дундаж талбайн хэмжээ 2024 онд 223.6 дм.кв байсан бол 2025 онд 245.7дм.кв бол 9.9 хувиар тус тус өссөн байна. Эдгээр үзүүлэлтүүд нь компанийн үйл ажиллагааны ашигт ажлын эффициент өсөж буйн илэрхийлэл гэж дүгнэж байна.

Гүйцэтгэх удирдлагын баг 2025 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн бүхий л нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшлуулах алхмуудыг хийж, бизнесийн орчны өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд зах зээл, орчин нөхцөлд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

Иймд “Булигаар” хувьцаат компанийн ТУЗ-ийн зүгээс 2025 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “Хангалттай” гэсэн дүгнэлт өгч байна.

НОГДОЛ АШИГ ТАРААХ ЭСЭХ ТУХАЙ



“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 02/26

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, “Булигаар хувьцаат компанийн дүрэм”-ийн 10 дугаар зүйлийн 10.5, Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. “Булигаар” ХК нь 2025 оны санхүүгийн жилийн ашигт ажллага зорилгод түвшинд хүрээгүй, Ногдол ашиг төлсний дараа компанийн төлбөрийн чадварт нөлөөлж болзошгүй тул Булигаар ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2. дахь хэсгийн 2.2.1. дэх заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
- Хоёр. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 88.2% буюу дунд засаглалтай гэж үнэлэгдэж байсан бол 2025 оны эхний хагас жилийн үнэлгээгээр 93.1%-ийн гүйцэтгэлтэй гарсан нь өмнөх оны үнэлгээнээс 5.5%-иар өсч 5-р байранд жагсав.

25

Д/д	Компанийн нэрс	Үнэлгээ	Байр
1	"ГОВЬ" ХК	98.6%	1
2	"ХААН БАНК" ХК	98.6%	
3	"ПРЕМИУМ НЭКСУС" ХК	98.6%	
4	"АПУ" ХК	97.2%	2
5	"БОДЬ ДААТГАЛ" ХК	97.2%	
6	"ТЕХНИК ИМПОРТ" ХК	97.2%	
7	"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК	95.8%	3
8	"МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ" ХК	95.8%	
9	"СҮҮ" ХК	95.8%	
10	"СЭНДЛИ ББСБ" ХК	95.8%	
11	"ХАСБАНК" ХК	95.8%	4
12	"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХК	94.4%	
13	"ТӨРИЙН БАНК" ХК	94.4%	
14	"ТҮМЭН ШУВУУТ" ХК	94.4%	
15	"ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК" ХК	94.4%	
16	"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" ХК	94.4%	5
17	"БУЛИГААР" ХК	93.1%	
18	"ЛЭНДМН ББСБ" ХК	93.1%	
19	"ШИВЭЭ ОВОО" ХК	93.1%	6
20	"АЙТҮҮЛС" ХК	91.7%	
21	"ГОЛОМТ БАНК" ХК	91.7%	
22	"ИНВЕСКОР ББСБ" ХК	91.7%	
23	"МИК ХОЛДИНГ" ХК	91.7%	7
24	"АРД ДААТГАЛ" ХК	90.3%	
25	"ТЕРМЕС ЦЕНТР" ХК	90.3%	

ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

1. Төмөрбаатар овогтой Болд
2. Чулуунбаатар овогтой Нямдорж
3. Жадамба овогтой Эрдэнэбат

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

4. Батчулуун овогтой Анхболд
5. Батчулуун овогтой Баянжаргал
6. Анхболд овогтой Энхмэнд
7. Довжид овогтой Гансүх
8. Бямбабаяр овогтой Баттүшиг
9. Цэрэндагва овогтой Мөнхлхагва

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

1. Төмөрбаатар БОЛД

Боловсрол

1987 – 1992 он ЗХУ-ын Украины Машин байгууламжийн дээд сургууль, Инженер

Ажлын туршлага

1992 – 1995 он Монголын хөрөнгийн бирж, Хяналтын ажилтан
 1995 оноос Дэлгэрхангай брокерийн пүүс, Брокер
 2017 оноос Даац инвестмент ХХК, Гүйцэтгэх захирал
 2017 оноос Монголын Үнэт цаасны бирж, ТУЗ-ийн ердийн гишүүн
 2021 оноос Тэлмэн групп ХХК, ТУЗ-ийн ердийн гишүүн
 2022 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн**

2. Чулуунбаатар НЯМДОРЖ

Боловсрол

1988 – 1992 он Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Нягтлан бодогч, эдийн засагч
 1997 – 2000 он Монгол Улсын Их Сургууль, Эрх зүйч
 2003 он Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага

1992 – 1993 он ШУА-ын харьяа Хөдөө Аж Ахуйн Эдийн засгийн хүрээлэн, Эрдэм шинжилгээний ажилтан
 1993 – 1995 он Чингэлтэй дүүргийн Татварын алба, ТУБ
 1995 – 2014 он Төрийн хянан шалгах хороо, Нийслэлийн аудитын газар, Хянан байцаагч, ахлах хянан байцаагч, ахлах шинжээч
 2014 – 2020 он Одбүртгэл аудит болон Мүүрь Аудит ХХК, Мэргэжлийн үйлчилгээ хариуцсан дэд захирал
 2021 оноос Тэргэл менежмент ХХК, Гүйцэтгэх захирал
 2022 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн**

3. Жадамба ЭРДЭНЭБАТ

Боловсрол

1987–1992 он Монгол Улсын Их Сургууль, Математикч

Ажлын туршлага

1992 – 1996 он Монгол Улсын Их Сургуулийн ТИС, Багш
 1996 – 2001 он Ноён суудал брокерын пүүс, Гүйцэтгэх захирал
 2002 – 2004 он Ханын материал ХК, Санхүү эрхэлсэн захирал
 2013 – 2016 он Хөдөө аж ахуйн бирж, Гүйцэтгэх захирал
 2017 – 2020 он Монголын Үнэт цаасны бирж, Гүйцэтгэх захирал
 2020 – 2022 он Эрдэс баялгийн бирж, Гүйцэтгэх захирал
 2022 оноос Тэргэл менежмент ХХК, Шинжээч ажилтан
 2022 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

4. Батчулуун АНХБОЛД

Боловсрол

1990 – 1994 он Монгол Улсын Их Сургууль, Худалдааны эдийн засагч
 1995 – 1996 он Монгол Улсын Их Сургууль, Мэдээлэл зүйн магистр

Ажлын туршлага

1994 – 1996 он МУИС-ийн Эдийн засгийн сургууль, Мэдээлэл зүйн багш
 1998 – 2000 он Санком ҮЦК ХХК, Диллер
 2001 – 2018 он Дархан Минж ХХК, Ерөнхий захирал, гүйцэтгэх захирал
 2019 – 2024 он Булигаар ХК, Гүйцэтгэх захирал
 2019 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

5. Батчулуун БАЯНЖАРГАЛ

Боловсрол

1996 – 2000 он Монгол Улсын Их Сургууль, Эдийн засагч

Ажлын туршлага

2000 – 2006 он Монгол шуудан банк, Нягтлан бодогч
 2006 оноос Дархан Минж ХХК, Гүйцэтгэх захирал, дэд захирал
 2019 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

5. Анхболд ЭНХМЭНД

Боловсрол

2013 – 2016 он ИБУИИНВУлсын Вестминстерийн Их Сургууль, Хөрөнгө оруулалтын санхүүч

Ажлын туршлага

2016 – 2017 он Монголын үнэт цаасны бирж ХХК, Төлбөр тооцооны ахлах ажилтан
 2017 он Ард секюритиз УЦК ХХК, Хөрөнгө оруулалтын аналитст
 2018 он Монгол шир төсөл, Парк таун бонд, Санхүүгийн зөвлөх
 2018 – 2019 он Екап ХХК, Үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулалт хариуцсан захирал
 2020 – 2021 он Лугати ХХК, Гүйцэтгэх захирал
 2021 – 2022 он Мөнх Орших Капитал ББСБ ХХК, Гүйцэтгэх захирал
 2022 оноос Алтан Хоромсог үнэт УЦК ХХК, Гүйцэтгэх захирал
 2019 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн дарга**

7. Довжид ГАНСҮХ

Боловсрол

1986 – 1991 он ОХУ-ын Барилгын Их Сургууль, Барилгын технологич

Ажлын туршлага

1993 – 1995 он ТТҮБ траст ХХК, Барилгын даамал

1995 – 2004 он Зэндмэнэ инвест ХХК, Гүйцэтгэх захирал

2004 – 2013 он Дархан Минж ХХК, Үйлдвэрлэл хариуцсан захирал, Үйлдвэрлэлийн менежер

2014 – 2018 он Сүлд Ивээл Констракшн ХХК, Захирал

2019 – 2024 он Булигаар ХК, Үйлдвэрлэл хариуцсан захирал

2024 оноос Нихон инвест ХХК, Гүйцэтгэх захирал

2019 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

8. Бямбабаяр БАТТҮШИГ

Боловсрол

2012 – 2016 он БНТУ-ын Эге их сургууль, Арьс шир боловсруулах инженер

2016 – 2018 он Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Санхүүгийн удирдлагаар магистр

Ажлын туршлага

2016 – 2019 он Монгол Шевро ХК, Технологич

2019 – 2024 он Булигаар ХК, Технологич

2024 оноос Булигаар ХК, Гүйцэтгэх захирал

2023 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

9. Цэрэндагва МӨНХЛХАГВА

Боловсрол

2001 – 2005 он Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн КтМС, Бизнесийн удирдлага

2006 – 2007 он Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн КтМС, Хүний нөөцийн менежментээр магистр

Ажлын туршлага

2005 – 2007 он МАТ ХХК, Менежер

2007 – 2008 он Гангар Инвест ХХК, Хүний нөөцийн менежер

2008 – 2016 он Алтайн Хүдэр ХХК, Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн, хэлтсийн захирал

2016 – 2018 он ТМГ групп, Хүний нөөцийн зөвлөх

2019 – 2025 он Булигаар ХК, Хүний нөөцийн ахлах менежер

2022 оноос **Булигаар ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн**

ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

БУЛИГААР ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалт, Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

.....

БУЛИГААР ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтад заасны дагуу баталсугай.
- Хоёр. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, цалин хөлс, урамшууллыг үр дүнг харгалзаж олгож байхыг Төлөөлөн Удирдах Зөвлөл-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

.....

БУЛИГААР ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, Булигаар ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.1, 7.18, 7.19 дэх заалт, 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах гишүүдийн бүрэлдэхүүнээр сонгосугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:.....

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:.....

Хоёр. Компанийн дүрмийн 7.19-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нэг жил буюу дараа жилийн компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.

Гурав. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад дүрэм журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

.....

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн
03/26 тоот тогтоолын Хавсралт 2

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овогнэр

Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Эзэмшиж буй хувьцааны тоо

Бүртгэсэн /Брокер дилерийн компани/

Брокерийн овог нэр

Хурал хуралдах газар, өдөр: **“Булигаар” ХК-ийн хурлын танхимд**

/УБ хот, ХУД, 20-р хороо, компанийн 2-р давхарт/

2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 13:00 цагт

Хэлэлцэх асуудал 1, 2-ын хүрээнд санал хураах арга: **Ердийн**

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах			
2	Компанийн ТУЗ-ийн цалин урамшуулал, зардлын төсөв батлах			

Заавар: Та өөрийн саналыг (“\ “болон “+”) тэмдгээр тэмдэглэнэ.

Брокер.....гарын үсэг

/тэмдэг/

Хувьцаа эзэмшигч..... гарын үсэг

2026 оны -р сарын өдөр

Засварласан болон балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
 ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС
 /ТУЗ-ийн гишүүдийг сонгох/**

Хэлэлцэх асуудал 3-ын хүрээнд санал хураах арга: **Кумулятив**

Саналын эрхтэй нийт хувьцааны тоо:

*/Эзэмшиж буй хувьцааны тоо * 9 гишүүн = Саналын эрхтэй нийт хувьцааны тоо/*

№	ТУЗ-д нэр дэвшигчдийн нэрс	Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо
Хараат бус гишүүд		
1	Төмөрбаатар овогтой Болд	
2	Чулуунбаатар овогтой Нямдорж	
3	Жадамба овогтой Эрдэнэбат	
Ердийн гишүүд		
4	Батчулуун овогтой Анхболд	
5	Батчулуун овогтой Баянжаргал	
6	Анхболд овогтой Энхмэнд	
7	Довжид овогтой Гансүх	
8	Бямбабаяр овогтой Баттүшиг	
9	Цэрэндагва овогтой Мөнхлхагва	

Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг	
Овог нэр:	
Гарын үсэг:	
Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг	
Хуулийн этгээдийн нэр:	
Улсын бүртгэлийн дугаар:	
Хувьцаа эзэмшигч хувь хүн болон хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бөглөх хэсэг	
Овог нэр:	
Гарын үсэг:	

2026 оны -р сарын өдөр

Засварласан болон балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.
 - Та саналын хуудсыг бөглөхдөө тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн хувилбарын зөвхөн нэгийг сонгож, аль нэг нүдэнд нь “√” эсвэл “+” тэмдгээр тэмдэглэнэ.
 - Засварласан болон балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
2. Хэрэв та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцдаг брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Улаанбаатар хот, ХУД, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Булигаар ХК, 2 давхар хаягаар 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 13:00 цаг дотор ирүүлнэ үү.
3. Та урьдчилан санал өгсөн бол дахин тухайн асуудалд санал өгөх эрхгүй.
4. Хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд биеэр ирж оролцож байгаа тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд танилцуулагдаж дууссаны дараа, Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргын зааврын дагуу Тооллогын комисст өөрийн бөглөсөн саналын хуудсыг өгнө.
5. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулах ба тухай саналын хуудсыг итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
6. Саналыг **кумулятив** аргаар тоолох асуудалд:
 - Саналыг кумулятив аргаар тоолох асуудлын хувьд санал өгөх эрхийн тоо нь таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.
 - Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нь 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно.



БУЛИГААР
хувьцаат компани